

**МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ  
СТАНДАРТ НЭВТРҮҮЛЭХ МРЦМ/20240203312 ТЕНДЕРИЙН  
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА**

Үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд ISO/IEC 27001 Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог үр дүнтэйгээр нэвтрүүлж үйл ажиллагаандаа бүрэн ашиглахад гол зорилго оршино.

Үүнд:

1. Үйлдвэрийн газрын одоогийн Мэдээллийн аюулгүй байдлын стандартын шаардлагыг хангаж буй зэрэглэлийг тогтоох зөрүүний шинжилгээ хийх /GAP/.
2. Стандартыг нэвтрүүлэхэд шаардлагатай сургалтуудыг зохион байгуулах.
3. Стандартын хэрэгжилтийг хангахад шаардлагатай дотоод аудиторуудыг бэлтгэх сургалтуудыг зохион байгуулж, гэрчилгээ олгох.
4. Мэдээллийн аюулгүй байдлын ерөнхий мэдлэг олгох сургалтыг бүх ажилтанд зохион байгуулах.
5. Стандартын шаардлагыг хангахад шаардлагатай баримт бичиг боловсруулахад арга зүйн туслалцаа үзүүлэх.
6. Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO/IEC 27001 стандартын баталгаажуулалтад бэлтгэх.
7. Хамтарсан аудит хийх

<b>Хэрэгжүүлэх үйл ажиллагаа</b>	<b>Хугацаа</b>
ISO/IEC 27001 стандарт нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээ үзүүлэх <ul style="list-style-type: none"> <li>• Зөрүүгийн шинжилгээ</li> <li>• Төслийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө</li> <li>• Үйлдвэрийн газарт стандарт шаардлага хангах жишиг баримт бичиг, журам</li> <li>• Стандарт хэрэгжүүлэлтийн удирдамж, гарын авлага</li> <li>• 5-10 дотоод аудитор бэлдэх</li> <li>• 1-2 тэргүүлэх аудитор бэлдэх</li> <li>• Хэрэгжүүлэлтийн сургалт</li> </ul>	4-6 сар

**Тавигдах шаардлага**

**/Жич: Доорх шаардлагуудын нотлох материалуудыг эх хувиас хуулбарлан ирүүлэх/**

<b>1.</b>	<b>Тавигдах шаардлага</b>
	<ul style="list-style-type: none"> <li>• Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд байх</li> <li>• Стандартыг нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээний байгууллага нь олон улсын стандартын гэрчилгээ олгох эрхтэй байх.</li> <li>• Зөвлөх үйлчилгээний байгууллага нь энэхүү стандартын чиглэлээр ахлах аудитор болон дотоод аудиторуудыг бэлтгэсэн туршлагатай байх.</li> <li>• Төслийн багийн ахлагч нь мэдээллийн технологийн салбарт хамгийн багадаа 10 жил ажилласан, ижил төстэй төслийг амжилттай удирдаж байсан туршлагатай байх.</li> <li>• Төслийн багийн ахлагч нь ISO/IEC 27001 стандарт болон бусад олон улсын стандартуудыг нэгтгэн хэрэгжүүлж байсан туршлагатай ба хамгийн багадаа энэхүү стандартыг 3 байгууллагад амжилттай нэвтрүүлж байсан туршлагатай байх.</li> <li>• Мэргэжлээр 5-аас доошгүй жил ажилласан ISO/IEC 27001 аудиторын</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>• сертификаттай 2-аас доошгүй орон тооны ажилтантай байх</li> <li>• ISO/IEC 27001 стандарт нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээний багтай байх</li> <li>• Зөвлөх багийн ахлагч нь магистр ба түүнээс дээш зэрэгтэй байх</li> <li>• ISO/IEC 27001 ахлах аудиторын сертификаттай ажилтантай байх</li> <li>• Стандарт нэвтрүүлэхтэй холбоотой сургалтын материал, гарын авлагаар хангах</li> </ul>
<b>2.</b>	<b>ISO/IEC 27001 стандарт нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээ үзүүлэх</b>
	<ul style="list-style-type: none"> <li>■ GAP шинжилгээ, чанарын болон тоон судалгааны боловсруулалт хийдэг программ хангамж, судалгаа явуулах арга аргачлал, мэдээллийн баазтай байх</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>■ Ажилтнуудын сургууль төгссөн диплом, зэрэг, мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээний хуулбар ирүүлэх</li> </ul>
<b>3.</b>	<b>Үйлдвэрийн газрын хэмжээнд хэрэгжүүлэх бодлогын баримт бичиг боловсруулах</b>
	Үйлдвэрийн газрын хэмжээнд нэвтрүүлэн ашиглах мэдээллийн аюулгүй байдлын бодлогын баримт бичиг болон бусад дагалдах журмуудыг боловсруулах
<b>4.</b>	<b>Сургалтын хөтөлбөр ирүүлэх</b>
	<ul style="list-style-type: none"> <li>• ISO/IEC 27001 стандартын талаар ерөнхий мэдлэг олгох /Бүх ажилчдад/</li> <li>• Дотоод аудитор бэлтгэх</li> <li>• Тэргүүлэх аудитор бэлтгэх</li> </ul>